



САНГИЙН ЯАМ

Монгол Улсын хагас жилийн эдийн засаг, төсвийн тойм

2023

АГУУЛГА

ХҮСНЭГТ	3
ЗУРАГ	3
I. Макро эдийн засгийн хагас жилийн тойм	4
Эдийн засгийн өсөлт	4
Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн.....	4
Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн.....	5
Гадаад худалдаа	6
Төлбөрийн тэнцэл	7
Инфляц	8
II. 2023 оны нэгдсэн төсвийн хагас жилийн гүйцэтгэл	10
Төсвийн орлого.....	12
Төсвийн зарлага.....	15
Нийгмийн даатгалын сангийн төсөв.....	18
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв.....	18
Улсын төсвийн хөрөнгө оруулалт.....	19
Гадаад зээл, тусламжийн ашиглалт.....	21
Засгийн газрын өр.....	24
Засгийн газрын дотоод үнэт цаас.....	25
Засгийн газрын гадаад үнэт цаас.....	25
Засгийн газрын гадаад зээл.....	25
Барих-шилжүүлэх концесс.....	26
III. Макро эдийн засаг, төсвийн төсөөлөл	27
Эдийн засгийн өсөлт	27
Гадаад худалдаа	27
Инфляц	27
Төсвийн орлого	27
Төсвийн урсгал зарлага	28
Засгийн газрын өрийн төсөөлөл	28
Макро эдийн засгийн төсөөлөл	29

ХҮСНЭГТ

ХҮСНЭГТ 1. ДНБ, 2023 оны эхний хагас жилд.....	4
ХҮСНЭГТ 2. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар.....	4
ХҮСНЭГТ 3. ДНБ зэрэгцүүлэх үнээр, өөрчлөлт эхний улирлаар.....	5
ХҮСНЭГТ 4. Хагас жилийн экспорт, импортын гүйцэтгэл.....	6
ХҮСНЭГТ 5. Төлбөрийн тэнцэл, хагас жилийн урьдчилсан гүйцэтгэл.....	8
ХҮСНЭГТ 6. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, тодотголын дараах дүн.....	10
ХҮСНЭГТ 7. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, хагас жилийн гүйцэтгэл.....	11
ХҮСНЭГТ 8. Улсын нэгдсэн төсвийн алдагдлын санхүүжилт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	11
ХҮСНЭГТ 9. Улсын нэгдсэн төсвийн орлого, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар ..	12
ХҮСНЭГТ 10. Улсын нэгдсэн төсвийн зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	16
ХҮСНЭГТ 11. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	18
ХҮСНЭГТ 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар.....	19
ХҮСНЭГТ 13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хагас жилийн гүйцэтгэл.....	20
ХҮСНЭГТ 14. Гадаад зээл, тусламжийн хүлээгдэж буй гүйцэтгэл.....	21
ХҮСНЭГТ 15. Гадаад зээл, тусламж хөгжлийн түншээр.....	22
ХҮСНЭГТ 16. Засгийн газрын өрийн бүтэц, тэрбум төгрөг.....	24
ХҮСНЭГТ 17. Макро эдийн засаг болон улсын төсвийн үзүүлэлтүүд.....	29

ЗУРАГ

ЗУРАГ 1. ДНБ өсөлт бууралт, хувиар.....	4
ЗУРАГ 2. Эдийн засгийн өсөлт, бууралт салбараар.....	5
ЗУРАГ 3. Хагас жилийн экспорт, импорт, тэнцэл.....	6
ЗУРАГ 4. Экспорт, импорт түнш орнуудаар, %.....	7
ЗУРАГ 5. Инфляцын түвшин, сүүлийн нэг жилээр.....	8
ЗУРАГ 6. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл.....	11
ЗУРАГ 7. Татварын орлогын бүтэц, хувиар.....	14
ЗУРАГ 8. Урсгал зардлын бүтэц, хувиар.....	17
ЗУРАГ 9. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг.....	24
ЗУРАГ 10. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг.....	25
ЗУРАГ 11. Гадаад үнэт цаасны хүү.....	25
ЗУРАГ 12. Гадаад зээл.....	26
ЗУРАГ 13. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл.....	26

I. Макро эдийн засгийн хагас жилийн тойм

Эдийн засгийн өсөлт

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн

2023 оны эхний хагас жилд Үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн **30.5** их наяд төгрөгт хүрч, эдийн засаг өмнөх оны хагас жилээс **6.4 хувиар** өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2023 оны эхний хагас жилд **13.6 их наяд төгрөгт** хүрч дэлхийн нийтийг хамарсан КОВИД-19 цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас өмнөх түвшинд хүрлээ.

Эдийн засгийн бодит өсөлтийг салбараар авч үзвэл Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих боомтын болон дэд бүтцийн томоохон төслүүдийн үр дүнд бий болсон экспортын сэргэлтийн нөлөөгөөр уул уурхайн салбар 45.2 хувиар тэлж, түүнийг дагасан тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 74.0 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.6 хувиар, үйлчилгээний салбар 7.4 хувиар тус тус өссөн нь нийт өсөлтийг дэмжих гол хүчин зүйл болжээ.


Харин цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр том малын зүй бус хорогдол эрс өсөж хөдөө аж ахуйн салбар 9.9 хувиар буурсан нь нийт өсөлтийг хязгаарласан байна.

ХҮСНЭГТ 1. ДНБ, 2023 оны эхний хагас жилд

/их наяд.төг/	2019	2020	2021	2022	2023
ДНБ, оны үнээр	17.9	17.0	19.9	23.4	30.5
ДНБ, 2015 оны з.үнээр	13.0	11.8	12.6	12.8	13.6

Эх үүсвэр: УСХ

ЗУРАГ 1. ДНБ өсөлт бууралт, хувиар



ХҮСНЭГТ 2. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

/тэрбум.төг/	2015 оны зэрэгцүүлэх үнээр					Оролцоо /хувь/
	2019.I	2020.I	2021.I	2022.I	2023.I	
ДНБ	12,973.	11,811.	12,554.4	12,807.9	13,630.8	6.4%
Хөдөө аж ахуй	1,830.5	2,057.4	1,963.2	2,186.1	1,969.6	-1.7%
Уул уурхай	1,907.4	1,306.5	1,613.9	1,117.8	1,623.4	3.9%
Аж үйлдвэр барилга	1,452.9	1,407.9	1,417.3	1,399.5	1,433.8	0.3%
Боловсруулах үйлдвэрлэл	790.6	743.9	831.8	812.9	825.7	0.1%
Цахилгаан	333.7	341.2	372.7	392.	410.4	0.1%
Барилга	328.7	322.8	212.9	194.6	197.7	0.0%
Үйлчилгээ	6,071.9	5,541.8	5,710.7	6,036.4	6,483.3	3.5%
Худалдаа	1,370.6	1,164.3	1,224.9	1,395.2	1,486.6	0.7%
Тээвэр, агуулах	531.8	360.6	397.2	319.5	556.	1.8%
Мэдээлэл, холбоо	286.3	302.	361.2	405.5	451.6	0.4%
Бусад үйл ажиллагаа	3,883.2	3,715.	3,727.5	3,916.2	3,989.1	0.6%
Цэвэр татвар	1,710.4	1,497.5	1,849.3	2,068.	2,120.7	0.4%

Хөдөө аж ахуйн салбар 2023 оны эхний хагас жилд 9.9 хувиар буурахад том малын зүй бус хорогдол 17.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

2023 оны эхний хагас жилд Архангай, Увс, Хэнтий зэрэг аймгуудад хаваржилт хүндэрсний улмаас 2022 оны эхний хагас жилд 218 мянга байсан том малын зүй бус хорогдол 3.9 саяд хүрч өссөнөөр ДНБ-д **1.7** нэгж хувийн буурах нөлөө үзүүлжээ.

Уул уурхайн олборлолтын салбарын нэмэгдэл өртөг өсөхөд нүүрс олборлолт **2.1 дахин**, газрын тос олборлолт **32 дахин** өссөн нь ДНБ-д **3.9** нэгж хувиар эерэг нөлөө үзүүлэв.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын эрчимжилт дотоодын эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлж, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг өсөхөд нөлөөлсөн байна.

Бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ ДНБ-д **0.4** хувийн эерэг нөлөө үзүүлсэн ба үүнд орлогын албан татвар 64 хувь, нийгмийн даатгалын орлого 30 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 21 хувь, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 116 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас тайлбарлахад эцсийн хэрэглээ 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 6 нэгж хувиар, бүтээгдэхүүний цэвэр экспорт 38.5 нэгж хувиар нэмэгдсэн нь өсөлтийг дэмжсэн бол хөрөнгийн хуримтлал -29.1 нэгж хувиар буурсан нь өсөлтийг хязгаарлах хүчин зүйл болсон байна.

ХҮСНЭГТ 3. ДНБ зэрэгцүүлэх үнээр, өөрчлөлт эхний улирлаар

/тэрбум төгрөг/	2015 оны зэрэгцүүлэх үнээр					Оролцоо /хувь/
	2019.I	2020.I	2021.I	2022.I	2023.I	
ДНБ	12,793.5	11,831.6	12,562.5	12,542.3	13,315.2	6.2%
Эцсийн хэрэглээ	10,718.1	11,471.2	10,446.9	11,211.7	11,879.9	5.3%
Өрхийн хэрэглээ	8,619.5	9,166.3	8,320.6	8,943.1	9,183.4	1.9%
Төрийн хэрэглээ	2,098.5	2,304.9	2,126.3	2,268.7	2,696.5	3.4%
Хөрөнгийн хуримтлал	4,422.4	3,308.5	4,786.6	6,581.5	4,666.8	-15.3%
ҮХ-н нийт хуримтлал	3,838.2	3,043.3	3,426.3	3,896.0	4,229.1	2.7%
МЭХ-н өөрчлөлт	584.3	265.2	1,360.4	2,685.6	437.7	-17.9%
БҮЦ экспорт	(2,347.0)	(2,948.1)	(2,671.1)	(5,251.0)	(3,231.4)	16.1%
БҮ-ний экспорт	6,994.1	5,120.4	5,836.3	5,005.0	10,656.3	45.1%
БҮ-ний импорт (-)	9,341.1	8,068.5	8,507.3	10,256.0	13,887.7	29.0%

-Өрхийн хэрэглээний дүнд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

-Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

Эх үүсвэр: УСХ

Эцсийн хэрэглээ ДНБ-ий өсөлтөд **5.3** хувийн эерэг нөлөө үзүүлэхэд өрхийн эцсийн хэрэглээ 2023 оны эхний хагас жилд 9.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өссөн, төрийн байгууллагын хэрэглээ 2.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар тус тус 1.9, 3.4 нэгж хувиар өсөлтийг дэмжсэн байна.

Цэвэр экспортын хэмжээ 2023 оны эхний хагас жилд -3.2 их наяд төгрөгт хүрч алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 38.5 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Үүнд барааны экспорт 4.0 их наяд төгрөгөөс 8.8 их наяд төгрөгт хүрч 119.1 хувиар өссөнөөр барааны цэвэр экспорт 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарсан нь ДНБ-ий өсөлтөд **16.1** хувийн эерэг нөлөө үзүүлэхэд голлон нөлөөлжээ.

Харин хөрөнгийн хуримтлал **15.3** хувийн эерэг оролцоо нь үндсэн хөрөнгийн нийт хуримтлал өмнөх оны мөн үеэс 38.2 хувиар, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт өмнөх оны мөн үеэс 56.1 хувиар тус тус өссөнтэй холбоотой байна.

Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2023 оны эхний хагас жилд 3.4 их наяд төгрөгийн алдагдалтай, хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 0.7 их наяд төгрөгийн ашигтай гарснаар Үндэсний нийт орлого 27.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 37.3 хувиар өслөө.

Гадаад худалдаа

Монгол Улс 2023 оны эхний хагас жилд нийт 143 улстай худалдаа хийж, экспорт **7.6** тэрбум америк доллар, импорт **4.3** тэрбум америк долларт хүрэв.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ **11.8** тэрбум америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.9%-р өсөж, худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1.9 тэрбум ам.доллараар өсөж, **3.3** тэрбум ам.долларт хүрлээ.

ЗУРАГ 3. Хагас жилийн экспорт, импорт, тэнцэл




ХҮСНЭГТ 4. Хагас жилийн экспорт, импортын гүйцэтгэл

/ сая ам.доллар/	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023 I-VI	Өөрчлөлт I-VI 2022/2023
Эргэлт	5,288.3	7,347.6	9,257.2	11,838.0	27.9%
Экспорт	2,828.2	4,072.7	5,308.3	7,564.4	42.5%
Эрдэс бүтээгдэхүүн	2,020.6	3,387.7	4,436.9	6,595.3	1,409.6%
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	8.0	44.9	2.1	90.2	4,195.2%
Ургамлын гаралтай бүт	4.5	86.9	2.9	133.3	4,496.6%
Нэхмэл бүтээгдэхүүн	118.4	212.0	265.1	185.1	-30.2%
Үнэт чулуу, металл	607.1	221.3	517.2	344.1	-33.5%
Импорт	2,460.1	3,261.1	3,948.1	4,273.6	8.2%
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	197.7	278.9	366.3	308.9	-15.7%
Эрдэс бүтээгдэхүүн	485.4	551.9	877.5	1,008.9	15.0%
Үндсэн төмөрлөг	235.6	247.1	424.8	378.1	-11.0%
Тээврийн хэрэгсэл, сэлбэг	374.1	708.7	621.6	827.0	33.0%

Хими, химийн үйлдвэр бүт	173	270.5	274.7	236.3	-14.0%
Хуванцар, каучук	100.7	116.9	162.5	176.8	8.8%
Машин, механик төхөөрөмж	526.4	576.6	604.6	775.6	28.3%
Тэнцэл	368.0	825.4	1,361.2	3,290.8	141.9%

Нийт экспортын 91 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн (чулуун нүүрс 57%, зэс 18%), 3 хувийг мал аж ахуйн бүтээгдэхүүн, 3 хувийг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.

ЗУРАГ 4. Экспорт, импорт түнш орнуудаар, %



Уул уурхайн экспорт 2023 оны эхний хагас жилд тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 3.6 тэрбум ам.доллаар өсөж, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1.3 тэрбум ам.доллаар буурсан байна.

Нийт импорт 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 8 хувиар өсөхөд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 8 нэгж хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 3 нэгж хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Худалдааны түнш орон, бараагаар харвал ОХУ-аас импортлолсон барааны **71.3** хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортлолсон барааны **72.7** хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортлолсон

барааны **10.0** хувийг ачааны тэрэг эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2023 оны эхний хагас жилийн байдлаар 473.7 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын албан нөөц 3,817.8 сая ам.долларт хүрсэн. Уг нөөц нь валютын төлбөртэй барааны импортын нийт 5 орчим сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

2023 онд экспортод гаргах нүүрсийг нээлттэй, цахим арилжаагаар хийх, хилийн үнээр борлуулах, боомтуудын нэвтрүүлэх чадварыг сайжруулснаар нүүрсний экспорт эрс нэмэгдсэн нь урсгал данс ашигтай гарахад голлох нөлөөг үзүүллээ.

Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагуудаас нийт 420.4 тэрбум төгрөгийн урт хугацаат, хөнгөлөлттэй төслийн зээл, 118.7 тэрбум төгрөгийн гадаад тусламж, АДБХОБ-аас 100 сая ам.долларын хөтөлбөрийн зээлийг авч ашигласан нь валютын нөөцийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөг үзүүлсэн. Мөн арилжааны банкнууд болон аж ахуйн нэгжүүд гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас хэд хэдэн урт хугацаат санхүүжилтийг татаад байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас гадаад өрийн менежментийг амжилттай хэрэгжүүлж байгаа ба 2017 онд авч байсан Гэрэгэ бондын үлдэгдэл болох 387 сая ам.долларыг амжилттай төлж барагдуулсан байна.

ХҮСНЭГТ 5. Төлбөрийн тэнцэл, хагас жилийн урьдчилсан гүйцэтгэл


/сая ам.доллар/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023 I-VI	Өөрчлөлт 2022/2023
Урсгал данс	-743.4	-882.7	-1,087.9	-1,360.8	385.3	-128%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-149.4	-565.2	-417.6	-988.4	1,034.5	-205%
Анхдагч орлого	-713.7	-445.8	-880.4	-573.9	-827.9	44%
Хоёрдогч орлого	119.6	128.3	210.1	201.5	178.7	-11%
Хөрөнгийн данс	57.3	51.2	49.2	54.6	61.9	13%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл	-686.1	-831.5	-1,038.8	-1,306.3	447.2	-134%
Санхүүгийн данс	-1,098.4	-419.2	-690.8	-925.8	-199.8	-78%
Шууд хөрөнгө оруулалт	-1,053.9	-924.2	-920.2	-515.9	-613.3	19%
Багцын хөрөнгө оруулалт	-360.3	527.7	61.5	157.5	64.3	-59%
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	2.1	-2.5	-1.8	-11.0	0.9	-108%
Бусад хөрөнгө оруулалт	313.8	-20.3	169.6	-556.4	348.3	-163%
Алдаа болон орхигдуулга	43.7	-266.9	293.8	-677.5	-173.3	-74%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	456.0	-679.2	-54.2	-1,058.0	473.7	-145%

Эх үүсвэр: Монголбанк

Инфляц

Улсын хэмжээнд инфляц 2023 оны эхний хагас жилийн инфляц **10.6** хувь болж өмнөх оны мөн үеэс **6.3** нэгж хувиар буурсан хэдий ч Монголбанкны инфляцын зорилтот түвшин болох **6±2** хувиас өндөр байна.

ЗУРАГ 5. Инфляцын түвшин, сүүлийн нэг жилээр



Үүнд хэрэглээний сагсан дах 410 нэр төрлийн бараа, үйлчилгээний 42 нь үнэ тогтвортой, 34 нь үнэ буурсан нь эергээр нөлөөлсөн бол 334 бараа, үйлчилгээний үнийн түвшин өссөн нь голлон нөлөөлжээ.

2022 онд БНХАУ-ын “Тэг-Ковид” стратегийн нөлөөгөөр хилийн хорио цээр, тээврийн үнийн өсөлт, ОХУ-Украины мөргөлдөөнтэй холбоотой нийлүүлэлтийн тасалдлаас шалтгаалсан инфляцын өсөлтийг Монгол Улсын Засгийн газраас тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдолыг арилгах боломжит бүхий л арга хэмжээг, шуурхай авч хэрэгжүүлсний үр дүнд инфляцын хурд тогтмол саарч байна.

Авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээг дурдвал “Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хүрээнд мах, гурилын дотоодын нөөц бүрдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгож, “РОСНЕФТЬ” ХНН-тэй АИ-92 автобензины тонн бүрийг 25 хувийн хямдруулсан үнээр худалдан авах гэрээ байгуулж, шаардлагатай нөөц бүрдүүлэх эргэлтийн хөрөнгөд нь Засгийн газрын зүгээс баталгаа гаргасан.

Түүнчлэн дотоодоос хангах боломжгүй цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тос зэрэг импортын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнүүдийг “Гаалийн албан татвар”-аас чөлөөлөх арга

хэмжээг авч хэрэгжүүлсэн нь импортын үнэ өндөр үед иргэд, ААН-д үзүүлэх инфляцын сөрөг нөлөөллийг бууруулсан алхам боллоо.

2023 оны эхний хагас жилд БНХАУ-ын “Тэг-Ковид” стратегийг орхин хил, тээврийн нөхцөл байдал эргэн сайжирч, автобензин, дизель түлшний хилийн үнэ буурсан, мөн төлбөрийн тэнцлийн эерэг урсгалаас шалтгаалан валютын ханш тогтвортой байсан нь инфляц саарахад эерэг нөлөө үзүүллээ.

II. 2023 оны нэгдсэн төсвийн хагас жилийн гүйцэтгэл

Төсвийн тодотгол

2023 оны 6-р сард Монгол Улсын засгийн газар дараах эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан төсвийн тодотгол хийсэн ба 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлогоос шалтгаалсан сорилт, тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Инфляцын түвшин сүүлийн 20 сарын турш 10 хувиас өндөр байгаа нь иргэдийн бодит орлогыг буурахад нөлөөлсөн.

Монгол Улсын Засгийн газраас экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг арилгах чиглэлд “уурхайн ам” нөхцөлөөр хямд зарагдаж байсан нүүрсээ БНХАУ-ын талтай хамтран ажиллаж, биржээр дамжуулан “хил” нөхцөлөөр ил тод, нээлттэй борлуулж эхэлсэн. Үүний үр дүнд Монгол Улс 2023 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого давж биелэх хүлээлттэй байна.

Иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах, гол дагуух дэд бүтэц болон нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төсөв хоорондын зохицуулалт хийх шаардлага тулгарсан.

ХҮСНЭГТ 6. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, тодотголын дараах дүн


/тэрбум.төг/	2023 Бат	2023 Тод	Зөрүү
Нийт орлого	19,722.3	21,823.5	2,101.2
Тогтворжуулалтын сан	132.7	501.6	368.9
Ирээдүй өв сан	540.0	540.0	0.0
Тэнцвэржүүлсэн орлого (I)	19,049.6	20,781.9	1,732.3
Нийт зардал (II)	20,475.3	22,371.4	1,896.1
Урсгал зардал	15,247.5	16,914.1	1,666.6
Хөрөнгийн зардал	5,359.7	5,616.1	256.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-132.0	-159.0	-27.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл (I-II)	-1,425.7	-1,589.5	-163.8
ДНБ-д эзлэх хувь	-2.6%	-2.6%	-

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр **11.1** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **3.1** (38.2%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 10.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **3.2** (44.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, хагас жилийн гүйцэтгэл

/тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023* I-VI	
Нийт орлого	5,548.8	4,358.7	7,106.1	8,001.5	11,059.3	56.0%
Ирээдүй өв сан	616.6	246.5	417.7	-	0	0.0%
Тогтворжуулалтын сан	31.8	12.0	259.7	653.6	477.9	360.1%
Тэнцвэржүүлсэн орлого (I)	4,900.4	4,100.3	6,428.7	7,347.9	10,581.3	55.6%
Нийт зардал (II)	4,708.3	6,298.3	7,498.2	8,191.9	9,033.8	44.1%
Урсгал зардал	3,962.3	5,050.8	6,559.6	7,004.8	7,556.6	49.6%
Хөрөнгийн зардал	636.1	1,228.9	859.6	1,158.9	1,443.9	26.9%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	109.9	18.7	78.9	28.2	33.3	-25.2%
Тэнцвэржүүлсэн тэнцэл (I-II)	192.2	-2,198.0	-1,069.5	-844.0	1,547.5	-108.5%

ЗУРАГ 6. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл



Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 оны эхний хагас жилд **9.0** их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл **1.5** их наяд төгрөгийн ашигтай гарчээ.

ХҮСНЭГТ 8. Улсын нэгдсэн төсвийн алдагдлын санхүүжилт, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Эх үүсвэр /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023* I-VI	<u>2023*I-VI</u> 2021 I-VI
АЛДАГДЛЫН САНХҮҮЖИЛТ	-192.2	2198.0	1069.5	844.0	-1547.5	-183.36
Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	-359.9	1079.4	1310.4	704.7	-1275.6	-181.01
Засгийн газрын бонд	-78.9	-62.1	-468.3	-125.5	-646.0	5.1 ¹
Засгийн газрын зээл	246.4	1159.9	227.1	263.8	373.6	141.61
Дотоод	0.0	-44.1	0.0	0.0	0.0	-
Гадаад	246.4	1204.0	227.1	263.8	373.6	116.2
Өмч хувьчлал	0.2	20.8	0.3	1.0	0.6	60.1

¹ -дахин их

Төсвийн орлого

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого **2023** оны эхний хагас жилийн байдлаар **11,059.3** тэрбум төгрөгт болж, энэ нь өмнөх оны мөн үеэс **2.9** их наяд төгрөгөөр буюу **36.9** хувиар өссөн үзүүлэлт юм.

ЗГ-с авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Төсвийн орлогод учирч буй эрсдэлийг бууруулах, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах зорилгоор Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, боомтуудын ачаа тээврийн хэсгийг өргөтгөх ажлыг үргэлжлүүлж, голлох боомтуудад шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэн Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх, Шивээхүрэн-Сэхээ боомтыг ойрын хугацаанд нээн, үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.
- Татварын бүртгэлийг сайжруулах, цахимжуулах, цахим төлбөрийн баримтын системийг үе шаттай хөгжүүлэх замаар далд эдийн засгийг бууруулах, татварын суурийг өргөжүүлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг нээлттэй арилжих замаар борлуулалт, тээвэрлэлтэд хяналт тавих цогц системийг бий болгох, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжоор хангах, улс орны эдийн засгийн өсөлтөд тус салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор нэвтрүүлж буй “Уул уурхайн бүтээгдэхүүний бирж”-ийн тогтолцоог дэмжиж ажиллаж байна.

ХҮСНЭГТ 9. Улсын нэгдсэн төсвийн орлого, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар


Орлогын төрөл /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023* I-VI	2023* 2022
НИЙТ ОРЛОГО	5,548.8	4,358.7	7,106.1	8,001.5	11,059.3	138.2
ИРЭЭДҮЙН ӨВ САН	616.6	246.5	417.7	0.0	0.0	-
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	31.8	12.0	259.7	653.6	477.9	-26.9
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	4,900.4	4,100.3	6,428.7	7,347.9	10,581.3	144.0
ТАТВАРЫН ОРЛОГО	4,446.2	3,742.9	5,588.4	6,940.7	9,841.2	141.8
Орлогын албан татвар	1,142.5	919.6	1,848.2	1,552.7	2,551.6	164.3
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	751.8	537.4	1,356.2	988.6	1,781.2	180.2
Хувь хүний орлогын албан татвар	425.7	415.1	523.7	612.1	831.0	135.8
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	299.4	302.6	375.7	458.7	634.8	138.4
Үйл ажиллагааны орлогын	20.6	20.8	26.6	33.6	32.4	96.4
Хөрөнгийн орлого	54.0	56.2	69.7	45.7	48.5	106.1
Хөрөнгө борлуулсны орлогын	3.2	4.7	26.7	30.4	34.2	112.4
Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.4	0.4	0.2	0.1	0.5	493.3
Шууд бус орлого	48.0	30.3	24.8	43.6	80.6	184.9

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-35.0	-33.0	-31.7	-48.0	-60.6	126.2
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	924.6	786.1	994.5	1,386.4	1,795.4	129.5
Хөрөнгийн албан татвар	88.0	79.6	94.7	123.6	198.5	160.6
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	54.1	46.2	56.1	75.5	140.0	185.4
Бууны албан татвар	0.6	0.4	0.5	0.5	0.5	101.1
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар	33.4	33.1	37.8	42.4	51.7	121.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,050.5	953.6	1,345.8	1,804.7	2,182.2	120.9
Дотоодын бараа, үйлчилгээний	473.8	452.0	601.4	773.6	907.4	117.3
Импортын барааны	757.4	700.6	883.0	1,197.4	1,486.2	124.1
НӨАТ-ын буцаан олголт	-180.7	-199.0	-138.6	-166.3	-211.4	127.1
Онцгой албан татвар	427.1	365.2	396.1	466.0	374.0	-19.7
Дотоодын архи, дарсны	97.0	74.5	79.7	121.7	109.4	-10.1
Дотоодын тамхины	16.4	11.5	12.1	15.0	8.4	-43.7
Дотоодын шар айргийн	12.7	10.9	17.1	20.2	17.4	-14.1
Импортын архи, дарсны	3.8	3.8	8.3	12.1	15.1	124.8
Импортын тамхины	49.5	53.1	64.4	68.8	69.4	100.9
Импортын шар айргийн	0.8	1.0	2.1	2.4	2.9	121.1
Суудлын автомашины	129.9	89.5	94.9	144.0	140.9	-2.1
Автобензин, дизелийн түлшний	117.1	121.0	117.4	81.9	10.4	-87.3
Тусгай зориулалтын орлого	7.5	8.0	6.5	9.4	10.2	108.8
Автобензин, дизелийн түлшний татвар	7.5	8.0	6.5	9.4	10.2	108.8
Гадаад үйл ажиллагааны орлого	362.9	335.8	441.4	582.7	685.6	117.7
Импортын барааны гаалийн албан татвар	362.9	335.8	441.3	582.7	685.6	117.7
Экспортын гаалийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	443.0	294.8	461.3	1,015.3	2,043.6	2.0 ¹
Нийтлэг бусад төлбөр, хураамж	366.6	220.1	365.0	886.1	1,905.0	2.1 ¹
Улсын тэмдэгтийн хураамж	24.3	20.8	59.4	23.7	47.7	2.0 ¹
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	16.3	14.6	14.6	15.1	15.8	104.6
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	250.9	132.5	226.3	804.2	1,734.4	2.1 ¹
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3.0	3.7	0.4	0.6	0.8	139.3
Агаарын бохирдлын төлбөр	27.3	16.5	30.7	10.2	31.4	3.1 ¹
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7.8	8.8	8.9	10.0	12.6	126.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.1	0.9	1.1	1.6	2.3	144.7
Ус бохирдуулсны төлбөр	0.0	0.0	0.2	1.5	1.1	-29.3
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад төлбөр, хураамж	35.7	22.3	23.4	19.1	58.8	3.1 ¹
Газрын төлбөр	49.0	50.5	64.2	96.3	92.9	-3.6
Байгалийн нөөц ашигласны төлбөр	24.1	21.9	29.5	27.6	38.6	139.9
Ойн нөөц ашигласны төлбөр	1.4	1.7	6.6	2.6	3.2	122.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.3	0.3	0.3	0.7	0.2	-76.8
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	21.5	19.9	21.9	24.2	34.9	144.3
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.0	0.1	0.9	0.1	0.3	3.2 ¹
Бусад татвар	3.3	2.3	2.5	5.2	7.1	137.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	454.3	357.4	840.3	407.2	740.2	181.8

Нийтлэг татварын бус орлого	436.4	345.7	798.6	330.1	620.1	187.9
Хувьцааны ногдол ашиг	1.0	2.2	14.5	9.0	74.7	61.8
Хүүгийн орлого	22.2	36.3	27.1	19.7	48.6	2.4 ¹
Торгуулийн орлого	36.2	34.0	40.2	52.7	65.5	124.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	135.8	143.2	177.0	165.9	223.2	134.5
Түрээсийн орлого	1.1	2.0	1.9	2.2	2.3	103.4
Газрын тосны орлого	111.0	33.7	105.0	1.8	143.7	79.8 ¹
Навигацийн орлого	75.9	50.2	32.0	16.0	0.0	0.0
Нэр заагдаагүй бусад орлого	53.1	44.1	400.9	62.7	62.1	-1.0
Хөрөнгийн орлого	0.3	0.4	0.5	2.2	1.3	-39.5
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.3	0.4	0.5	2.2	1.3	-39.5
Тусламжийн орлого	17.6	11.3	41.3	74.9	118.7	158.5
Хандив тусламж, гадаад	17.6	11.3	41.3	74.9	118.7	158.5

¹ -дахин их

ЗУРАГ 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Татварын нийт орлого 2023 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр **9.8** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **2.9** (41.8%) их наяд төгрөгөөр өсөхөд бусад татварын орлого **1.0** (2.0 дахин) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар **377.5** (20.9%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого **409.0** (29.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 оны эхний хагас жилд **9.0** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **841.9** (10.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Төсвийн зарлагын эрсдэл

2023 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляц 10 хувиас дээш түвшинд хүрсэн нь иргэдийн бодит орлогыг 5.9 хувиар буурахад нөлөөлсөн байна. Монгол Улсын Засгийн газраас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүссэн тул 2023 оны 6-р сард төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулсан.

Төсвийн тодотголын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын голлох арга хэмжээнүүдээс дурдвал:

- Төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэчлэл хийсэн.
 - Цалин хөлс: Төрийн албаны цалингийн шинэчлэлийн хүрээнд хэт олон сүлжээ, шатлал бүхий харилцан адилгүй, тэгш бус үнэлэмжтэй төрийн албаны цалингийн тогтолцоог нэгтгэх замаар адил үнэлэмж бүхий ажил хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчийн цалин ижил байх зарчимд нийцүүлсэн.
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгосон.
 - Засгийн газраас хүүхдийн мөнгийг хүсэлт гаргасан өрхийн хүүхдэд олгохын зэрэгцээ энэ оны 1 дүгээр сараас хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд хүсэлт гаргасан тохиолдолд 2023 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн нөхөн олгож эхлээд байна.
- Тэтгэврийн зөрүүг арилгаж, инфляцаар нэмэгдүүлсэн.
 - 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт өндөр настны тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг тогтооход баримталсан цалин хөлсийг 2022 оны дундаж цалингаар суурь болгон шинэчлэн тооцсон. Энэ арга хэмжээний үр дүнд ижил цалин хөлсөөр ойролцоо хугацаанд ажиллан шимтгэл төлсөн боловч тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамаарч хоорондоо зөрүүтэй тэтгэвэр авч байгаа 164.6 мянган өндөр настны тэтгэврийн зөрүүг арилгасан. Үүний зэрэгцээ тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулж 10.0 хувь нэмэхээр тооцсон.
- Нийгмийн халамжийн тэтгэвэр, зарим тэтгэмжийг нэмэгдүүлсэн.
 - Нийгмийн даатгалаас тэтгэвэр авах эрх үүсээгүй хүнд олгох халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж тус бүр 288.0 мянган төгрөг байгааг нэгэн адил 325.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн, түүнчлэн нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж 84.5 мянган төгрөг байгааг 275.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн, мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмж 123.1 мянган төгрөг байгааг 275.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн.
- Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг хүүхдэд зориулан зарцуулна.
 - “Хүүхдийн төлөө сан”-ийн хуримтлагдсан орлогоос бүтээн байгуулалт болон олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцож амжилт гаргасан хүүхдүүдийг шагнаж урамшуулах зардлыг 2023 оны төсөвт нэмж тусгасан.


ХҮСНЭГТ 10. Улсын нэгдсэн төсвийн зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Зарлагын төрөл /тэрбум.төг/	2019	2020	2021	2022	2023*	Өөрчлөлт
	I-VI	I-VI	I-VI	I-VI	I-VI	2023*/2022
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4 708.3	6 298.3	7 498.2	8191.90	9033.8	110.3
НИЙТ ЗАРЛАГА	4 598.4	6 279.6	7 419.3	8163.7	9000.5	110.3
УРСГАЛ ЗАРДАЛ	3 962.3	5 050.8	6 559.6	7004.8	7556.6	107.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 885.3	2 164.2	2 056.3	1640.0	2044.6	124.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 158.0	1 339.2	1 295.4	827.2	951.2	115.0
Үндсэн цалин	858.7	950.3	917.3	545.9	581.2	106.5
Нэмэгдэл	216.3	291.1	291.2	212.9	280.8	131.9
Унаа хоолны хөнгөлөлт	26.8	29.3	26.7	31.1	46.6	149.9
Урамшуулал	42.3	54.3	45.8	19.6	23.6	120.6
Гэрээт ажлын хөлс	13.9	14.1	14.3	17.7	18.9	106.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133.4	141.5	138.8	162.9	195.3	119.9
Гэрэл, цахилгааны зардал	25.2	26.6	23.4	29.7	36.8	123.8
Түлш, халаалтын зардал	86.2	92.5	94.1	105.2	126.1	119.8
Цэвэр, бохир усны зардал	11.4	9.8	7.4	12.0	14.0	116.9
Байрны түрээс	10.6	12.6	13.9	16.0	18.4	115.2
Хангамж, бараа материалын зардал	62.8	76.9	73.0	80.7	85.0	105.4
Норматив зардал	134.9	142.5	79.5	111.2	119.7	107.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68.0	71.1	41.1	34.7	36.4	104.8
Хоолны зардал	50.5	49.6	22.6	58.6	73.4	125.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал	16.4	21.8	15.8	18.0	9.9	55.2
Эд хогшил, урсгал засварын зардал	33.1	35.6	25.4	39.5	47.1	119.3
Томилолт, зочны зардал	13.6	7.1	4.6	9.9	17.6	177.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208.3	238.1	264.5	247.1	408.0	165.1
Бараа үйлчилгээний бусад зардал	141.2	183.3	175.2	161.4	220.7	136.8
Бараа үйлчилгээний бусад зардал	124.2	168.5	162.0	152.3	208.8	137.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17.0	14.8	13.2	9.1	12.0	131.4
ХҮҮ	436.8	425.2	420.1	415.6	513.8	123.6
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	341.0	379.7	355.0	360.1	459.7	127.7
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	95.8	45.5	65.1	55.5	54.1	97.4
ТАТААС	123.0	376.8	202.7	267.9	266.5	99.5
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	32.8	49.0	26.0	69.9	76.8	109.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	90.2	327.9	176.7	198.0	189.7	95.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 517.2	2 084.5	3 880.5	4681.3	4731.8	101.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	39.7	85.7	385.5	2575.0	1733.6	67.3
Бусад урсгал шилжүүлгүүд	1 477.5	1 998.8	3 495.0	2106.3	2998.2	142.3
НД-н тэтгэвэр тэтгэмж	997.5	1 174.6	1 249.2	1590.5	1785.1	112.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	341.1	641.1	1 003.6	279.0	972.3	3.5 ¹

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2.0	2.5	1.6	2.8	3.1	112.3
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58.9	96.5	174.7	120.7	123.6	102.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52.1	55.8	35.5	53.7	62.1	115.6
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21.3	21.9	14.1	54.5	46.4	85.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4.6	6.3	1 016.2	5.0	5.6	111.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	636.1	1 228.9	859.6	1158.9	1443.9	124.6
Барилга байгууламж	469.9	763.1	490.1	911.4	979.9	107.5
Их засварын зардал	30.7	31.4	23.5	35.2	41.2	117.0
Тоног төхөөрөмж	24.2	153.6	86.7	50.6	188.2	3.7 ¹
Бусад хөрөнгө	100.8	266.7	250.4	159.8	233.3	146.0
Стратегийн нөөц хөрөнгө	10.4	14.0	9.0	1.9	1.3	70.4
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	109.9	18.7	78.9	28.2	33.3	118.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	58.2	-24.8	15.1	-34.8	-45.3	130.1
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	51.6	43.5	63.8	62.9	78.6	124.9

¹ -дахин их

ЗУРАГ 8. Урсгал зардлын бүтэц, хувиар



Зарлагын өсөлтөд бараа ажил үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс **404.7** (24.7%) тэрбум төгрөгөөр, хүүгийн зардал өмнөх оны мөн үеэс **98.2** (23.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин татаасны зардал **1.5** (-0.6%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Урсгал зардалд урсгал шилжүүлгийн эзлэх хувь 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс **1.1** нэгж хувиар өссөн байна.

Хөрөнгийн зардлын гүйцэтгэл **1.4** их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс **285.0** (24.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн зардалд барилга байгууламжийн зардлын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс **7.5** нэгж хувь, их засварын зардлынх **17** нэгж, бусад хөрөнгийн зардлынх **46** нэгж, тоног төхөөрөмжийн зардлынх **272** нэгж хувиар өсөж, стратегийн нөөц хөрөнгийн зардлынх **29.6** нэгж хувиар тус тус буурчээ.

Нийгмийн даатгалын сангийн төсөв

Нийгмийн даатгалын сангийн орлого 2023 оны эхний хагас жилд **1.9** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **269.1** (16.5%) тэрбум төгрөг, нийт зарлага **1.8** их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс **200.9** (12.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 11. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023* I-VI	2023* 2022
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,174.2	1,042.3	1,215.5	1,630.8	1,899.9	116.5
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО	871.5	758.8	944.5	1,225.6	1,591.0	129.8
Тэтгэврийн даатгалын шимтгэл	657.0	573.6	823.2	1,026.4	1,319.7	128.6
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	81.9	72.1	57.5	99.0	135.6	136.9
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	110.0	94.7	50.6	81.5	109.7	134.6
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	22.6	18.3	13.2	18.7	26.0	139.4
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	302.7	283.6	271.0	405.2	308.9	76.2
НИЙТ ЗАРЛАГА	1,009.6	1,187.3	1,260.6	1,600.3	1,801.1	112.6
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА	11.6	12.3	12.1	12.7	16.1	126.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8.4	9.0	9.1	9.8	12.8	130.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1.0	1.1	1.2	1.2	1.6	129.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.5	0.6	0.6	0.6	0.6	113.4
Хангамж, бараа материалын зардал	0.3	0.4	0.3	0.3	0.3	91.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.1	0.1	0.0	0.2	0.1	69.7
Томилолт, зочны зардал	0.1	0.0	-	0.0	0.1	2.7 ¹
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1.0	1.0	0.9	0.6	0.6	104.0
Бараа үйлчилгээний бусад зардал	0.1	0.0	0.0	0.1	0.0	62.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	998.0	1,175.0	1,249.6	1,591.0	1,785.5	112.2
Бусад урсгал шилжүүлэг	998.0	1,175.0	1,249.6	1,591.0	1,785.5	112.2
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	997.5	1,174.6	1,249.1	1,590.4	1,785.1	112.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.2	0.0	0.1	0.2	0.1	56.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.4	0.3	0.4	0.5	0.3	59.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.1	-	-	-	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-1.1	-3.5	-0.4	12.9
ТЭНЦЭЛ (+, -)	164.7	(145.0)	(45.1)	30.6	98.8	3.2¹

¹ -дахин их

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2023 оны эхний хагас жилд **766.4** тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс **43.2** (6.0 хувь) тэрбум төгрөг, нийт зарлага **799.5** тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс **259.4** тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт /тэрбум.төг/	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2023* I-VI	2023* I-VI 2022 I-VI
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	214.9	213.1	482.5	723.2	766.4	106.0
ЭМД-ын хураамжийн шимтгэл	214.9	213.1	482.5	723.2	766.4	106.0
НИЙТ ЗАРЛАГА	163.7	198.3	518.0	1,058.9	799.5	75.5
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА	1.5	1.7	6.3	9.4	4.9	52.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.7	0.9	1.5	2.0	2.3	115.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.1	0.1	0.3	0.2	0.3	126.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	0.0	0.1	0.1	0.8	875.4
Хангамж, бараа материалын зардал	0.1	0.1	0.1	0.1	1.2	11.9 ¹
Эд хогшил, урсгал засварын зардал	0.1	0.1	0.1	0.0	0.4	12 ¹
Томилолт, зочны зардал	0.1	0.1	0.0	0.0	2.0	5.6 ¹
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.3	0.4	1.3	6.8	6.8	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	0.1	0.1	2.9	0.1	0.7	1.1 ¹
ТАТААС	17.2	21.1	32.7	52.5	38.8	73.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145.0	175.5	479.5	1,000.2	758.2	75.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	144.9	175.4	479.5	1,000.1	758.1	75.8
Бусад урсгал шилжүүлэг	0.1	0.1	0.0	0.2	0.7	4.4 ¹
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.1	0.0	0.0	0.1	-	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	-	0.0	-	0.3	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	0.0	0.0	0.0	0.3	14 ¹
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	(0.6)	(3.2)	(2.5)	78.8
ТЭНЦЭЛ	51.2	14.8	(35.4)	(335.7)	(33.1)	9.9

¹ -дахин их

Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1139 төсөл, арга хэмжээнд 2,686.0 тэрбум төгрөг, концессын 4 төслийн эргэн төлөлтөд 279.6 тэрбум төгрөг, нийт 2,965.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан.

Үүнээс 2023 оны эхний хагас жилийн байдлаар:

- ✓ Өмнөх оноос дамжин шилжин хэрэгжиж буй 719 төсөл, арга хэмжээнд 479.7 тэрбум төгрөг,
- ✓ Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусган шийдвэрлэсэн барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилтэд 167.7 тэрбум төгрөг,
- ✓ 2023 онд шинээр эхлэн хэрэгжүүлж буй Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн автопаркийг шинэчлэх ажлын санхүүжилтэд 94.2 тэрбум төгрөгийг тус тус олгож нийт 741.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 25.0%-ийн гүйцэтгэлтэй байна.

Түүнчлэн 2023 оны эхний хагас жилийн байдлаарх гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэлийн хувь 4.2%-аар буурсан боловч санхүүжилтийн хэмжээг харвал 245.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Харин төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар харвал:

- ✓ Барилга байгууламжийн төслүүдийн санхүүжилтэд 485.2 тэрбум төгрөг
- ✓ Их засварын төслүүдийн санхүүжилтэд 23.1 тэрбум төгрөг
- ✓ ТЭЗҮ, Тоног төхөөрөмжийн төслүүдийн санхүүжилтэд 149.1 тэрбум төгрөг
- ✓ Концессын эргэн төлөлтөд 84.2 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

ХҮСНЭГТ 13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хагас жилийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагч /сая.төг/	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэл 2023.06	Гүйцэтгэл хувь	2023 ХБГ* 90%
Монгол улсын шадар сайд	3	10,345.7	7,543.8	982.8	13.03%	6,789.4
Монгол улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	2	55,634.1	43,193.8	344.1	0.80%	38,874.4
Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	31	84,828.5	23,091.1	6,196.3	26.83%	20,782.0
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	24	48,769.3	18,492.1	3,069.0	16.60%	16,642.9
Батлан хамгаалахын сайд	6	24,031.6	11,865.6	2,302.6	19.41%	10,679.1
Сангийн сайд	6	451,011.0	201,894.5	18,795.5	9.31%	181,705.0
Хууль зүй, дотоод хэргийн сайд	25	106,686.0	60,098.1	15,064.6	25.07%	54,088.3
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	33	132,989.6	36,841.3	12,243.8	33.23%	33,157.1
Барилга, хот байгуулалтын сайд	169	974,575.9	345,152.5	83,368.7	24.15%	310,637.3
Боловсрол, шинжлэх ухааны сайд	399	1,634,389.2	529,281.5	162,447.8	30.69%	476,353.3
Соёлын сайд	77	546,000.8	144,237.3	39,980.4	27.72%	129,813.6
Зам, тээврийн хөгжлийн сайд	120	1,577,015.7	408,821.9	74,042.9	18.11%	367,939.7
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	47	138,936.7	74,672.5	14,882.6	19.93%	67,205.3
Эрчим хүчний сайд	42	482,439.0	168,999.2	32,914.4	19.48%	152,099.3
Эрүүл мэндийн сайд	106	469,278.3	172,118.7	62,209.6	36.14%	154,906.9
Улсын ерөнхий прокурор	4	27,644.4	13,093.9	11,155.8	85.20%	11,784.5
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	572.5	458.0	130.8	28.56%	412.2
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	5	24,546.0	21,625.9	1,627.3	7.52%	19,463.3

Монгол улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	35	162,061.6	48,823.2	21,458.5	43.95%	43,940.8
Монгол улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	3	408,523.1	339,743.2	94,175.9	27.72%	305,768.9
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	1	15,967.1	15,967.1	-	0.00%	14,370.4
Улсын төсвийн дүн	1139	7,376,246.22	2,686,015.33	657,393.57	24.47%	2,417,413.8
Концессын дүн	4	541,524.7	279,590.4	84,213.9	30.12%	251,631.4
НИЙТ	1143	7,917,770.9	2,965,605.7	741,607.5	25.01%	2,669,045.2

*- Хүлээгдэж буй гүйцэтгэл

Гадаад зээл, тусламжийн ашиглалт

Монгол Улсын 2023 оны төсөвт гадаадын төслийн зээл, тусламжийг шинэ сэргэлтийн бодлогод туссан, нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх, хэрэгжиж байгаа төслүүдийг хугацаанд нь дуусгах бодлого чиглэлийг баримталж байна. Энэ хүрээнд нийт 1,795.0 тэрбум төгрөгийн гадаадын төслийн зээл, тусламжийг авч ашиглахаар төлөвлөгдсөнөөс эхний 6 сарын гүйцэтгэлээр 501.6 тэрбум төгрөгийг хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас хүлээн авч, төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлээд байна.

ХУСНЭГТ 14. Гадаад зээл, тусламжийн хүлээгдэж буй гүйцэтгэл

ЗАРДЛЫН АНГИЛАЛ	Гүйцэтгэл 2023 I-VI сар	ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ	2023 ХБГ*
Гадаад зээл, тусламж	501.6	28%	1,795.0
урсгал зардал	114.8	50%	227.5
хөрөнгийн зардал	295.0	23%	1,284.5
эргэн төлөгдөх	91.8	32%	283.0
Гадаад төслийн зээл	436.9	36%	1,224.5
урсгал зардал	100.9	57%	177.5
хөрөнгийн зардал	244.1	32%	764.0
эргэн төлөгдөх	91.9	32%	283.0
Гадаад тусламж	64.7	11%	570.5
урсгал зардал	13.9	28%	50.0
хөрөнгийн зардал	50.8	10%	520.5

*- Хүлээгдэж буй гүйцэтгэл

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголоор гадаад төслийн зээлийн ашиглалт 1,224.5 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 570.5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Эхний хагас жилийн байдлаар гадаадын зээл, тусламжийн ашиглалт 28 хувьд хүрсэн бол эхний хагас жилд төлөвлөгдсөн дүнтэй харьцуулбал 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд, зээлийн төслийн ашиглалт 36 хувь, гадаад тусламжийн төслийн ашиглалт 11 хувьтай байна.

Жилийн сүүлийн хагаст бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн гүйцэтгэлийг санхүүжүүлэх бөгөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр зээл, тусламжийн ашиглалт 1.8 их наяд буюу ДНБ-ний 3 хувьтай, нэгдсэн төсвийн нийт зарлагын 8 хувьтай байхаар тооцогдож байна.

ХҮСНЭГТ 15. Гадаад зээл, тусламж хөгжлийн түншээр

ХӨГЖЛИЙН ТҮНШ	2023 I-VI		ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ		2023 ХБГ*	
	зээл	тусламж	зээл	тусламж	зээл	тусламж
Австри	7.5	-	40%		18.6	-
АДБХОБ	-	-			0.5	-
АХБ	133.6	10.3	34%	15%	390.5	68.4
Беларусь	-	-			1.4	-
Боловсролын Дэлхийн Түншлэл	-	0.7		14%		4.7
БНСУ	39.7	-	50%		79.1	-
БНФУ	6.3	-	75%		8.3	-
БНХАУ	37.0	12.3	15%	11%	253.4	111.0
БНЭУ	116.5	-	68%		172.2	-
Дэлхийн банк	64.7	1.8	45%	15%	145.0	12.3
ЕСБХБ	21.8	2.3	20%	10%	109.6	23.8
ЕХОБ	1.9	-	11%		16.8	-
Польш	-	-	-		11.4	-
Унгар	-	-	-		-	-
ХААХОУС	0.5	-	26%		1.8	-
ХБНГУ	0.9	5.6	16%	22%	5.6	25.4
Япон	6.5	-	64%		10.2	-
АНУ	-	30.1	-	9%	-	313.8
Кувейт	-	1.4	-	23%	-	6.2
Люксембург	-	0.2	-	3%	-	5.4
НИЙТ	436.9	64.7	36%	11%	1,224.5	570.5

*- Хүлээгдэж буй гүйцэтгэл

2023 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 43.1 хувийг хөгжлийн түнш олон улсын байгууллага, 56.9 хувийг хөгжлийн түнш улс орнуудын эх үүсвэр бүрдүүлж байна.

Тухайлбал, БНЭУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн ЕРС-1 багц ажил буюу Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжийн барилга угсралтын ажил 2023 оны 11 дүгээр сард бүрэн дуусахаар төлөвлөгдсөн. Мөн БНСУ-ын “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн барилга угсралтын ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа ба төслийн хүрээнд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хэнтий аймгийн төвд 10 дулааны станц, 88 дулаан дамжуулах төв, 67 км урттай дулаан дамжуулах шугам сүлжээ барих ажил үргэлжлэн хэрэгжиж байна.

АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн Алтанбулаг, Замын Үүд боомтууд, Дархан-Уул аймагт мал, амьтны хорио цээрийн 3, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Дорноговь аймгийн Сайншанд сумуудад мал эмнэлгийн 2 лаборатори, Алтанбулаг боомтод мал, амьтны хорио цээрийн 1 байгууламж барих зорилтот ажлууд хийгдэж байна. Замын Үүд боомт дахь гаалийн хорио цээрийн лабораторийг хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Түүнчлэн “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын төсөл”-ийн хүрээнд Өвөрхангай, Архангай, Өмнөговь,

Дорноговь, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймгуудын төв, Хужирт сумын төвийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил, тохируулга, зүгшрүүлэлтийн ажил бүрэн дуусаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн бөгөөд төслийн хэмнэлт хөрөнгөөр Хэнтий аймгийн Бэрх сумын халаалтын зуухны засварын ажлыг хийж дуусган орон нутагт хүлээлгэн өгөөд байна.

Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдлийг өрийн хэрэгсэл тус бүрээр авч үзвэл 2022-2023 оны хагас жилийн хооронд, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл **2.3** хувиар өссөн, Засгийн газрын дотоод өрийн үлдэгдэл **37.1** хувиар, Засгийн газрын өрийн баталгаа, барих-шилжүүлэх концесс, орон нутгийн өрийн үлдэгдэл **16.2** хувиар буурсан үзүүлэлттэй байна.


ХҮСНЭГТ 16. Засгийн газрын өрийн бүтэц, тэрбум төгрөг

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ /тэрбум.төг/	2021 I-VI	2021	2022 I-VI	2022	2023 I-VI
I. Засгийн газрын дотоод өр	1,046.1	657.3	517.7	1,035.5	651.6
Үнэт цаас	1,046.1	657.3	517.7	1,035.5	651.6
II. Засгийн газрын гадаад өр	24,371.0	24,693.30	26,559.0	28,722.2	29,372.1
Үнэт цаас	7,976.2	8,175.60	8,994.9	9,359.8	9,070.6
Зээл	16,394.8	16,517.70	17,564.1	20,281.8	20,301.4
III. Засгийн газрын бусад өр	1,717.8	1,550.40	1,432.50	1,297.1	1,086.9
Засгийн газрын өрийн баталгаа	955.3	876.5	940.7	811.8	744.1
"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	762.5	673.9	470.5	474.0	342.8
Орон нутгийн зээллэг	-	17.2	21.0	12.3	0.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	27,135.0	26,918.10	28,508.8	31,964.8	31,110.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	22,337.8	21,837.30	23,810.5	27,690.6	27,033.6
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	70.0%	70.0%	70.0%	70.0%	65.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	51.9%	50.8%	50.1%	52.4%	46.2%

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар байдлаар нэрлэсэн дүнгээр **31.9** их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий **52.4** хувьд хүрээд байсан бол 2023 оны хагас жилийн байдлаар **31.1** их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий **46.2** хувьд хүрч буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тухай төсвийн тусгай шаардлагад өнөөгийн үнэ цэнэ /ӨҮЦ/-ээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2021-2022 онуудад **70** хувиас, 2023 онд **65** хувь, 2024 оноос эхлэн **60** хувиас тус тус хэтрэхгүй байхаар хуульчлагдсан.

ЗУРАГ 9. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг




Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ)-ийн ДНБ-д эзлэх харьцаа 2022 онд **52.4** хувийн гүйцэтгэлтэй байгаагаас 2023 оны хагас жилийн байдлаар **46.2** хувьд хүрээд байгаа нь хуулийн хязгаарыг хангаж байна. Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын тооцоолол нь ирэх онуудад бий болох эдийн засгийн өсөлт, Засгийн газрын өрийн баталгаа гаргах хэмжээ, валютын

ханшийн тооцоолол болон төсвийн алдагдал зэрэг макро эдийн засгийн суурь хүчин зүйлсээс шалтгаална.

Засгийн газрын дотоод үнэт цаас


ЗУРАГ 10. Монгол Улсын Засгийн газрын өр, тэрбум.төг



Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд Засгийн газрын үнэт цаас арилжаалаагүй тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 5 дахин буурч 2023 оны хагас жилийн байдлаар **651.6** тэрбум төгрөгт хүрсэн.

Засгийн газрын гадаад үнэт цаас

ЗУРАГ 11. Гадаад үнэт цаасны хүү



Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2023 оны 01 дүгээр сард “Сенчири-2” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан “Тэрэгэ” бондын 468.0 сая ам.доллар болон “Хуралдай” бондын 207 сая ам.доллартой тэнцэх хэмжээний өр төлбөрийн тодорхой хувийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж, гадаад өрийн хэмжээг бууруулах зорилгоор “Тэрэгэ” бондын 82 сая ам.долларын үлдэгдэл төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулаад байна.

Засгийн газрын гадаад зээл

Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2023 оны хооронд нийт 8,447.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ашиглалтыг 22 зээлдүүлэгчийн 326 төсөл хөтөлбөрт зарцуулсан. Үүнээс 2023 оны хагас жилийн байдлаар 2,533.1 сая ам.долларыг эргэн төлж 5,914.5 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.

Энэхүү гадаад зээлийн ашиглалтыг төслийн зээлийн хүрээнд 5,537.9 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,911.7 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг ашигласан бөгөөд гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.


ЗУРАГ 12. Гадаад зээл



Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын хамгийн их хэсэг буюу 2,332.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг дэд бүтцийн буюу зам, тээвэр, эрчим хүч, орон сууц, нийтийн аж ахуйн салбаруудад, 1,461.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг эргэлтийн хөрөнгө буюу жижиг дунд үйлдвэрлэлийн зээл, барааны зээл, банк санхүүгийн салбарт зэрэгт зарцуулсан бол үлдсэн 1,207.6 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хэсгийг нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээнүүд болох эрүүл мэнд, боловсрол, онцгой байдал зэрэг салбарын төслүүдэд авч ашигласан.

Барих-шилжүүлэх концесс

ЗУРАГ 13. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл



Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 концессын гэрээний үлдэгдэл 2023 оны хагас жилийн байдлаар **342.4** тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2 концессын гэрээний хүрээнд **0.4** тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Засгийн газар 2017 оноос хойш шинээр “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ байгуулаагүй бөгөөд өмнөх жилүүдэд байгуулагдсан гэрээний ашиглалтын хүрээнд өрийн үлдэгдэл нэмэгдэж ирсэн.

Ш. Макро эдийн засаг, төсвийн төсөөлөл

Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн 3 жилд цар тахал, геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас үүдсэн гадаад сөрөг нөлөөллийг сааруулж, эдийн засгийг сэргээх мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлж ирсэн бол дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж урт хугацааны зорилтыг хангах “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Оюутолгойн далд уурхайн үйлдвэрлэлийг эхлүүлж, уул уурхайн салбарын борлуулалтын гэрээ бүртгэлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй болж, экспортын биет хэмжээг цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүргэх зорилтыг хангаснаар 2023 онд уул уурхай, тээврийн салбар эдийн засгийн өсөлтийн гол хүч байхаар байна.

Мөн авто болон төмөр зам, эрчим хүчний төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжсэнээр барилгын салбарын өсөлтийг дэмжихээр байгаа бол оны эхэнд өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч, малын хорогдол өндөр байсантай холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарахаар төлөвтэй байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх дунд хугацааны бодлого, уул уурхай тээврийн салбарын эрчимжилт, эдийн засагт үүсээд байгаа богино хугацааны хүндрэлийг даван туулах бодлогуудын нөлөөг уялдуулан тооцсон бодит ДНБ 2023 онд 6.0 хувиар өсөхөөр хүлээгдэж байна.

Гадаад худалдаа

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 2023 онд 22.6 тэрбум ам.долларт, гадаад худалдааны тэнцэл 3.6 орчим тэрбум ам.долларын ашигтай байхаар хүлээгдэж байна.

Экспортын хилийн боомтууд дээр хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн ажлуудын үр дүнд нүүрсний экспортын хэмжээ төлөвлөж байснаас өсөхөөр хүлээгдэж байгаа тул экспортын хэмжээ 13.1 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.

Манай улсын эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаатай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон дизель түлш, машин механизм зэрэг үйлдвэрлэлийн орцын бүтээгдэхүүний импорт нэмэгдсэнээр нийт импортын дүн 2023 онд 9.5 орчим тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Инфляц

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээг 2023 онд үргэлжлүүлэхийн зэрэгцээ “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр хилийн саатлаас шалтгаалсан импортын бараа, түүхий эдийн үнийн өсөлт дунд хугацаанд тогтворжуулж, инфляцын түвшин 2023 оны эцэст нэг оронтой тоонд хүргэхээр зорьж байна.

Төсвийн орлого

Монгол Улсын 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэл батлагдсан түвшинд байхаар байна. Экспортолж буй байгалийн баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, экспортын үйл ажиллагааг саадгүй үргэлжлүүлэх, хилийн нэвтрүүлэх чадлыг тогтвортой хадгалах, хилээр нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр нийт 50.0 сая тонн нүүрс экспортлохоор

тооцлоо. Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний үр дүнд уул уурхайн салбараас нийт 6.1 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

Төсвийн урсгал зарлага

Төсвийн нийт урсгал зардал 2023 онд 16.9 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 60.0 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 14.0 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 16.0 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 6.0 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр, 4.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

Засгийн газрын өрийн төсөөлөл

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх үүн дотор зээлийн хөрөнгөөр авч ашиглаж буй зөвлөх үйлчилгээ, сургалт, семинар болон төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зардлыг багасгах, төсвийн сахилга батыг хангуулах. Мөн олон улсын байгууллагуудаас Монгол Улсад олгож буй хөнгөлөлттэй эх үүсвэрийг эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээд ашиглах чиглэлийг баримтлах;
- Өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж, боломжит хэмжээгээр гадаад үнэт цаасны төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулах;
- Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг нэвтрүүлэх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор арилжааг тогтмолжуулах;
- Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;
- Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулах зэрэг болно

Макро эдийн засгийн төсөөлөл

ХҮСНЭГТ 17. Макро эдийн засаг болон улсын төсвийн үзүүлэлтүүд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ	х/нэгж	2023 I-VI*	2023 ХБГ**
ДНБ, оны үнээр	их наяд төгрөг	30.5	62.4
Эдийн засгийн өсөлт	хувь	6.4	6.0
Инфляц	хувь	10.6	10.5
Гадаад худалдааны нийт эргэлт	тэрбум ам.доллар	11.8	22.6
Нийт экспорт	тэрбум ам.доллар	7.6	13.1
Нийт импорт	тэрбум ам.доллар	4.3	9.5
Гадаад худалдааны тэнцэл	тэрбум ам.доллар	3.3	3.6
УЛСЫН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ	х/нэгж	2023 I-VI*	2023 ХБГ**
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого	их наяд төгрөг	10.6	20.8
Нэгдсэн төсвийн нийт зарлага	их наяд төгрөг	9.0	22.4
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	их наяд төгрөг	1.5	-1.6
ДНБ-д эзлэх хувь	хувь	2.5	-2.6
ЗГ-н өрийн нийт хэмжээ	их наяд төгрөг	31.1	33.5
ДНБ-д эзлэх хувь	хувь	53.2	53.6

* Гүйцэтгэл

эх үүсвэр: СЯ, ЭЗХЯ

**Хүлээгдэж буй гүйцэтгэл

Холбоо барих

Веб хуудас: www.mof.gov.mn

Хаяг: Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн
гудамж, Засгийн газрын II байр Д корпус,
Улаанбаатар 15160, Монгол Улс
